

“ЭРҮҮЛ МЭНД ХӨГЖЛИЙН ТӨВ”-ИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/Б. НАРАНТУЯА/



“СБҮ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
/Н.БАТБОЛД/

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2017 оны 11 дугаар сарын 27-ны өдөр

2017 12 18 18 0

Улаанбаатар хот

Энэхүү **АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ** (цаашид “Гэрээ” гэнэ)-г нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид “Захиалагч” гэнэ), нөгөө талаас ХХК (цаашид “Ажил гүйцэтгэгч” гэнэ) (цаашид хамтад нь “Талууд”, тус тусад нь “Тал” гэнэ) нар Монгол улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцлийг харилцан тохиролцон байгуулав.

Гэрээний зүйл: Ажлын үр дүн

Ажлын нэр: ЭМХТөвийн төв байрны гадна Генераторыг байршуулах агуулах барих

Ажил үйлчилгээний төлбөр: **9 344 344** /Есөн сая гурван зуун дөчин дөрвөн мянга гурван зуун дөчин дөрвөн/ төгрөг

Гэрээний хугацаа: 2017.12.01-2017.12.15

### 1.Нийтлэг заалт

1.1 Энэхүү гэрээгээр Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн даалгаврын дагуу, Генераторыг байршуулах агуулах барих ажлыг гэрээнд заасан хугацаанд, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн Захиалагчийн өмчлөлд шилжүүлэх, ажлын гүйцэтгэлийн талаар Захиалагчийн эрх бүхий албан тушаалтанд тайлагнах, нөгөө талаас Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

### 2.Гэрээний хугацаа

2.1Энэхүү Гэрээ нь 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг дуустал 14 хоногийн /сарын/ хугацаатай байна.

2.2Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Ажил гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэж Захиалагч нь нэмэлт хугацаа тогтоож өгнө.

### 3.Ажил үйлчилгээний төлбөр

3.1Гэрээгээр гүйцэтгэх ажлын үйлчилгээний төлбөр нийт **9 344 344** /Есөн сая гурван зуун дөчин дөрвөн мянга гурван зуун дөчин дөрвөн/ төгрөг байна.



3.2 Захиалагч нь ажил үйлчилгээний төлбөрийн 70%- ийг урьдчилж хийх бөгөөд ажлын үр дүнг хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийн үлдэгдэл 30% Ажил гүйцэтгэгчийн Худалдаа хөгжлийн банкны 409031507 тоот дансанд шилжүүлнэ.

#### 4.Захиалагчийн эрх, үүрэг

4.1 Гэрээнд заасан хугацаа болон ажлын үр дүнг хүлээн авмагц ажил үйлчилгээний төлбөрийг төлөх үүрэгтэй.

4.2 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээн авах үүрэгтэй.

4.3 Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авсанаас хойших аливаа эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.

#### 5.Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд нь Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

5.2 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө ажлын үр дүнд учирч болох эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.

5.3 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.

#### 6.Бусад заалт

6.1 Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

6.2 Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон асуудлаар 2 тал харилцан тохиролцож хууль, тогтоомжид заасан үндэслэлээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

#### 7. Талууд

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ЭМХТ"-ийн ЗСҮА-ны хангамж,  
үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Ч.Тунгалаг

Гарын

үсэг: ..... *Ч.Тунгалаг* .....

Утас: 99062485

Хаяг: БЗД, 25-р хороо, Хүслийн  
өргөө 100/1-46 тоот

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“СБУ” ХХК-ийн Менежер

Я.Батцэцэг

Гарын

үсэг: ..... *Я.Батцэцэг* .....

Утас: 96663710

Хаяг: БЗД, 26-р хороо, Баянмонгол  
410-141 тоот